



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/788

Эрдэнэт

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/, 29.1.5/д/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний ээлжит 09 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүйтний улирал эхэлсэнтэй холбоотой архины хамааралтай иргэдэд амьдралын зөв дадал хэвшил олгох, нийгэмшүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч байнгын ажиллагаатай Архидалт мансуурлын эсрэг ассоциацийн Орхон аймаг дахь салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 10 000 000 /Арван сая/ төгрөгийг Төсөл хөтөлбөрийн зардлын жагсаалтын “Орон гэргүй тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх байнгын ажиллагаатай төвийг дэмжиж ажиллах” зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Цагдаагийн газар /н.Батбаяр/-т, Эрүүл мэндийн газар /н.Мөнхцэцэг/-т, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар /н.Эрдэнэбат/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc  
J201804070

Аймгийн Засаг даргын 2018 оны  
12 дугаар сарын 18 өдрийн  
А/488... дугаар захирамжийн хавсралт

**АРХИДАЛТ МАНСУУРЛЫН ЭСРЭГ ЭСРЭГ АССОЦИАЦИЙН  
ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН “АРХИНЫ ХАМААРЛАЙ ИРГЭДЭД  
АМЬДРАЛЫН ЗӨВ ДАДАЛ ХЭВШИЛ ОЛГОХ, ИТГЭЛ ҮНЭМШИЛ ТӨРҮҮЛЖ  
НИЙГЭМШҮҮЛЭХ” ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

| №                                           | Үйлчилгээ                      | Иргэдийн<br>тоо | Давтамж  | Зардал/1<br>хүн, өдөр/ | Нийт зардал<br>/төг/ |
|---------------------------------------------|--------------------------------|-----------------|----------|------------------------|----------------------|
| <b>1.Хоноглон байршуулах зардлын тооцоо</b> |                                |                 |          |                        |                      |
| 1                                           | Хоноглох байранд<br>байршуулах | 20              | 60 хоног | 5000                   | 6000000              |
| 2                                           | Халуун хоол, цай               | 20              | 60 хоног | 2000                   | 2400000              |
| 4                                           | Хордлого тайлах<br>эмчилгээ    | 20              | 1 удаа   | 80000                  | 1600000              |
| <b>Нийт дүн</b>                             |                                |                 |          |                        | <b>10000000</b>      |

Сэтгэл заслын эмчилгээ, сургалтууд тус байгууллагаас үнэ төлбөргүй хийгдэнэ.